



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/144

Улаанбаатар хот

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалт, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн 2016 оны төсөв батлах тухай” 2015 оны 32/33 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2016 оны А/368 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 1 дүгээр хэсгийн 1.3, 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Нийслэлийн авто замын ачааллыг зохицуулах арга хэмжээг зохион байгуулах тухай” А/368 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан 7 байршилд авто замын эргэлтийн талбай засварлах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, зөвлөмж хүргүүлэн ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны А/15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар байгуулагдсан Үнэлгээний хороо /Б.Энхбаяр/-нд үүрэг болгосугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Б.БАДРАЛ

